

МАХН-ЫН XVIII ИХ ХУРЛЫН МАТЕРИАЛААС

**МАРКСЧ-ЛЕНИНЧ НАР МАОИЗМЫГ
ИЛЧИЛЖ БАЙНА**

МАХН-ын ээлжит XVIII их хурал 1981 оны тавдугаар сард Улаанбаатар хотноо хуралдаж, 60 орны коммунист ажилчны болон хувьсгалт ардчилсан намын төлөөлөгчид оролцлоо. Их хурал орчин үеийн олон улсын байдал, түүний дотор дэлхийн хүн амын тэн хагасаас илүү нь оршин сууж байгаа Ази тивийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд оннгой анхаарал тавьж, тодорхой шинэ санал дэвшүүлэв. Их хурал дэлхий дахины улс тарийн уур амьсгалыг ноцтойгоор хүйтрүүлж байгаа АНУ тэргүүтэй олон улсын империализм, түүнтэй хоршин сүлбээлдэж буй Хятадын эрх баригч бүлгийнхний ард түмний эсрэг, социализмын эсрэг чиг бодлогыг ангич, зарчимч байр сууринаас шүүмжлэн няцаав.

МАХН-ын XVIII их хуралд тавьсан Төв Хорооны тайлан илтгэлд Ю. Цэдэнбал хэлэхдээ: «Хятадын өнөөгийн эрх баригчид олон улсын империалист хүчинтэй нэгэн эгнээнд явж байна. Эдийн засаг, улс төрийн талаар шахан хавчиж, бусад орны дотоод хэрэгт бүдүүлгээр хөндлөнгөөс оролцож, цэрэг дайны аюул занал бий болгон, хөрш улсуудын эсрэг зэвсэгт халдлага үйлдэж, шинэ колоничлолыг өөгшүүлэн дэвэргэж, фашист болон арьсны өнгөөр ялгаварлагч дэглэмүүдийг дэмжиж байгаа энэ бүхэн нь бээжингийн эрх баригчдын бодлогын салшгүй шинж чанар боллоо. Иймээс манай нам империализм, харгис хүчнийг эсэргүүцсэн тэмцлийг хятадын эрх баригчдын их гүрний жанжлах үзлийг эсэргүүцсэн тэмцэлтэй шууд холбосн үзэж байна» гэсэн билээ.

Манай намын тэр дүгнэлт, зорилтыг их хуралд оролцсон гадаадын зочид төлөөлөгчид өндрөөр үнэлж дэмжлээ.

МАХН-ын XVIII их хуралд гадаад зарим орны төлөөлөгчдөөс Хятадын удирдагчдын их гүрний жанжлах бодлогыг илчлэн шүүмжилсэн хэсгийг доор нийтлэв.

М. С. ГОРБАЧЕВ (ЗХУКН-ын төлөөлөгчдийн тэргүүн, ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга)

Одоо дэлхий дахины байдал нилээд нарийн ээдрээтэй байна. Империалист дайнч бүлгийнхэн зэвсгээр хөөцөлдөх явдлыг улам дэвэргэж бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг оролдож, нийгмийн дэвшлийн үйл хэргийг саатуулан зогсоохыг эрмэлзэж, дэлхий дахиныг дайны ирмэг рүү түлхэж байна. Империалистууд дэлхий дахины нөхцөл байдлыг хурцатгах явцдаа социалист хамтын нөхөрлөлийн эсрэг тэмцлийг гадаад бодлогынхоо нэг гол чиглэл болгосон бээжингийн эрх баригчдыг идэвхтэй хань хамсаатнаа болгож байна.

Асар уудам Ази тивийн байдал тайвангүй байна. Империализм, хятадын жанжлах үзэлтний бодлого нь Азийн орнуудын язгуур эрх ашигт шууд харшилж, тэдгээрийн аюулгүй байдалд заналхийлж байна.

Жишээлбэл АНУ цэргийн шинэ баазуудаа байгуулж Пакистаны нутаг дэвсгэр дээрээс Афганистан улсын эсрэг хувьсгалын эсэргүү түрэмгий халдлагыг зохион байгуулж, Пакистаныг эрчимтэй зэвсэглүүлж бай-

гаа нь үүнийг нотолж байгаа биш гэж үү? Бас Энэтхэгийн далайн бүс нутагт АНУ-ын цэрэг байлгах хэмжээг нийтдээ нэмэгдүүлж байгааг юу гэж үзвэл зохих вэ? Ази, Африкийн олон улс орон түүнийг өөрсдийнхөө тусгаар тогтнолд шууд аюул занал учруулж байна гэж үзэж байгаа нь үндэстэй юм.

Түүнчилэн америкийн империализм «түргэн байрлах хүч» гэгчийг байгуулж байгаа нь ямар учиртай юм бэ? Энэхүү цохих хүчийг АНУ-ын нутаг дэвсгэрээс олон мянган бээр хол зайтай газар ашиглаж, тэгэхдээ бусад орны эсрэг түрэмгий явууллага үйлдэх, империализмыг эсэргүүцэгч улс түмний чөлөөлөх тэмцлийг дарахын тулд ашиглахыг санаархаж байгаа юм.

Тэгээд ч бээжингийнхэн хаана л бол зөвхөн энх тайвны эрх ашиг төдийгүй, хятадын ард түмний эрх ашгийг үл ойшоон, энэ өдөөн хатгагч бодлогыг сүүдэр мэт бараадсаар байна. Хөрш зэргэлдээ улсууд, түүний дотор БНМАУ-ын талаар Бээжингийнхний явуулж байгаа дайсагнасан бодлого, Энэтхэг-хятадын хойгийн орнуудыг бүдүүлгээр хавчин шахаж байгаа явдал чухам үүнийг нотолж байна.

ГРИША ФИЛИПОВ (Болгарын Коммунист Намын төлөөлөгч)

Бээжингийн эрх баригчдын бодлого улс түмний аюулгүй байдалд заналхийлж байна. Хятадын эрх баригчид зөвлөлтийн эсрэг жанжлах бодлогоо үргэлжлүүлж, дэлхийн харгис хүчнийг дэмжихийн сацуу хөрш зэргэлдээ буюу бусад оронд өнгөлзөж, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцож, бүр давраад ил түрэмгийлж байна.

ВО ЧИ КОНГ (Вьетнамын Коммунист Намын төлөөлөгч)

Америкаар толгойлуулсан империализм тал бүрийн гүнзгий хямралд ороод байгаа ч гэсэн зэвсэглэлээр улам хүчтэй хөөцөлдөн, дэлхий дахинд заналхийлэхийн сацуу хятадын жанжлан эзэрхийлэгчидтэй хуйвалдан, дэлхийн хувьсгалт хөдөлгөөн, дэлхийн социалист системд хор хүргэхийг бүхий л аргаар оролдож байна. Бээжингийн өнөөгийн эрх баригчид хятадын ажилчин анги, ард түмнээс урван тэрсэлж ЗХУ, Монгол, Вьетнам болон социалист бусад орны эсрэг дайсагнасан бодлого явууллагаа элдвээр хүчтэй болгож байна. Империализмын дагуул болсон хятадын их гүрний эзэрхэг дээрэнгүй жанжлах үзэл дэлхийн болон Азийн улс түмний аюултай дайсан боллоо.

...бээжингийн эрх баригч харгис бүлэг Вьетнамыг эзлэн түрэмгийлэх замдаа гол саад тотгор гэж үзээд манай ард түмний эсрэг бузар муухай түрэмгий дайн дэгдээсэн юм. Бээжингийн эрх баригчид харгис явууллагаа идэвхжүүлэхийн зэрэгцээгээр Вьетнамын эсрэг шинэ түрэмгийлэл үйлдэх санаатайгаа байнга харуулж, лаос, кампучийн ард түмнийг улам хүчтэй хавчин хяхаж байна.

Гэвч Энэтхэг-хятадын хойгийн ард түмэн өөрсдийн орныг хамгаалж, бүтээн байгуулахын төлөө тэмцэлдээ бат нягтран, эв санааны нэгдлийн уламжлалт харилцаагаа хөгжүүлж, ЗХУ, Монгол, ах дүү социалист орнуудын харамгүй их тусламж, дэмжлэгт тулгуурлан империалистууд, хятадын эзлэн түрэмгийлэгч, жанжлагчдын бүх санаархал, явууллагыг таслан зогсоох зорилгоор хамаг хүчээ дайчлан тэмцэж байна.

Өөрийн тууштай бодлогод үнэнч ВКН, БНСВУ-ын засгийн газар, вьетнамын ард түмэн, хятадын ард түмэн, хятадын жинхэнэ хувьсгалчидтай найрамдалтай байхын төлөө, Хятадтай маргаантай асуудлыг тайван аргаар шийдвэрлэхийн төлөө гуйвалтгүй зогсож байна.

ЭРИХ МЮККЕНБЕРГЕР (Германы Нэгдмэл Социалист Намын төлөөлөгч)

...харгис хүчин социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас цэрэг стратегийн давуу байдал олж авахыг бүхий л аргаар эрмэлзэж байна. Өдөөн

хатгах, хомголзон жанжирхах бодлогоороо Бүгд Найрамдах Монгол Ард Улсад байнга аюул занал учруулж байдаг бээжингийн бүлгийнхэн тэдгээр харгис хүчнийг дэмжин өөгшүүлж байна.

ХОРХЕ РИСКЕТ ВАЛДЕС (Кубын Коммунист Намын төлөөлөгч)

Бид Ази тивийн ууган социалист оронд ирээд байна. Монгол улс өнөөдөр Вьетнам, Лаос, Кампучи, Афганистаны нэгэн адил бээжингийн эрх баригч эзлэн түрэмгийлэх харгис бүлгийн өдөөн хатгалга, дайсагнагч үйл ажиллагааны заналхийлэл дор оршиж байгааг тэмдэглэж хэлэх хэрэгтэй юм.

Вьетнамд бээжингийнхний өдөөн хатгалга нь шууд түрэмгийлэл болж хувираад, Хошимины баатарлаг ард түмэнд хэмжээлшгүй их гамшиг сүйрлийг тарьсан билээ. Тэнд хятадын жанжлах их гүрний дээрэнгүй үзэлтнүүд америкийн империалистуудын адилаар шившигтэйгээр ялагдсан юм.

Бээжингийн эрх баригч бүлэг Куба, Вьетнамыг гэсгээн цээрлүүлж сургамж өгнө гэж сүрдүүлж байсан боловч чухамдаа баатарлаг вьетнамын ард түмэн л өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хамгаалан эрслэн босч, нэгдэн нягтарсан ард түмэн ялагдашгүй юм гэсэн түүхэн үнэний сургамжийг тэдэнд үзүүлсэн юм.

Зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох, улс түмний хүсч мөрөөдөж байгаа энх тайван аюулгүй байдлыг хангах нэг үндэс болсон олон улсын хамтын ажиллагааны уур амьсгалыг тогтооход чиглэсэн хүчин чармайлтад хориг саад хийж, намжмал байдлын үйл явцыг тасалдуулах гэсэн америкийн империализмын түрэмгий бодлогын улмаас сүүлийн үед олон улсын байдал хурцдаж, түүнд хятадын эрх баригчдын улс төрийн бодлого, үйл ажиллагаа дэм болж байна.

ИШТВАН ШАРЛОШ (Унгарын Ажилчны Социалист Намын төлөөлөгч)

Хятадын удирдагчдын гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагааны алхам нь олон улсын түгшүүртэй байдлыг хүндрүүлсээр байна. Тэд үндсэрхэг жанжлах бодлогын хүсэл эрмэлзлэлээ удирдлага болгож, хятадын ард түмний жинхэнэ эрх ашгийг хөсөрдүүлж, империализмын хамгийн харгис бүлэглэлтэй илээр эвсэлдэж байна.

МИЛОШ ЯКЕШ (Чехословакийн Коммунист Намын төлөөлөгч)

Америкийн удирдагчдын ичгүүргүй явдал хир хэмжээнээс хэтэрлээ. Тэд дэлхийн аль ч районыг өөрийн эрх ашгийн хүрээний газар гэж зарлахад бэлэн байна. Энэ бодлогыг хятадын одоогийн удирдлага дэмжиж байна. Хятадын удирдагч, тухайлбал, Ази тивд, хөрш зэргэлдээ социалист улсуудад ихээхэн бэрхшээл учруулж байна. Үүнтэй холбогдуулан хятадын жанжлах үзлийг эсэргүүцэж, марксизм-ленинизм, социализм, пролетарийн интернационализмын тугийг өндөр өргөж яваа танай зарчимт бодлогыг бид өндөр үнэлж байна.

СИСОМФОН ЛОВАНСАЙ (Лаосын Ардын Хувьсгалт Намын төлөөлөгч)

Өнгөрсөн таван жилийн туршид манай орны эсрэг хорлон бусниулах ажиллагаа явуулж байнга занал учруулж байсан империалист хүчин, Бээжингийн эзлэн түрэмгийлэх, жанжлах үзэлтнүүд, бусад харгис хүчин хувьсгалын эсэргүү хорон санаагаар эвсэл холбоо байгуулж, бидний эсрэг явууллага хийсээр ирэв.

НУР АХМЕД НУР (Афганистаны Ардын Ардчилсан Намын төлөөлөгч)

Ховдог шунахай эрх ашгийнхаа үндэс суурийг алдсан том феодал, бусад харгис анги давхрааныхан, хүн алж, хүрээ талж гаршсан хувьсгалын эсэргүү дээрэмчид, америкийн империализм, хятадын их гүрний

дээрэнгүй үзэлтнүүд, пакистаны дайнчид болон бүс нутгийг харгис бүлгийнхний хөлсний этгээдүүд цөм манай хувьсгалын дайсан мөн. Тэд гутамшигт муухай фронтод нэгдээд хувьсгалт Афганистаны эсрэг зарлаагүй дайн хийж байна.

ГЕНРИ УИНСТОН (АНУ-ын Коммунист Намын төлөөлөгч)

...америкийн империализм нь милитарист, фашист дэглэмүүдийг газар сайгүй ивээн тэтгэж, АНУ-Бээжин-Японы цэргийн гурвалсан холбоо байгуулах гэсэн Бээжингийн удирдагчдын оролдлогыг хөхүүлэн дэмжиж байгаа юм.

Энх тайван, үндэсний эрх чөлөөний төлөө үйл хэргээс урван тэрсэлсэн хятадын удирдагчдын шившигт бодлогыг АНУ-ын Коммунист Нам шийдвэртэй буруушааж байна. Бээжингийнхэн америкийн империализмыг ивээн дэмжиж, хуйвалдсанаар империализмын нөлөөнөөс ангижрахын төлөө явуулж буй эрх чөлөөний хөдөлгөөний өсөлтийг удаашруулах, улс төрийн тусгаар тогтнолоо байлдан олсон эрх чөлөөний хөдөлгөөнийг сарниулан бусниулах, эдийн засгийн талаар биеэ даахад чиглэсэн тэмцлийн цаашдын дэвшилд нь саад учруулах, социалист чиг баримжааг сонгон авсан орнуудын хөгжлийн хүрдийг буцаан эргүүлэх, олон улсын валютын фондыг ашиглан эдгээр орнуудыг эдийн засгийн талаар хавчин хяхах, тэдний эсрэг болон социалист систем, ЗХУ-ын эсрэг цэрэг дайны үйл ажиллагаагаа явуулахын тулд цэргийн баазууд байгуулах, мөн эвсэлд нэгдээгүй орнуудын нэгдэл, нягтралыг сулруулахын тулд чадах бүхнээ хийх балмад бодлогоо үргэлжлүүлэн явуулахад нь тусалж байна. Ийм чиг шугамыг Бээжингийнхэн зориуд баримталж байна.

Энэ учраас империализмын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг Бээжингийнхэн АНУ-ын нэг адил огтхон ч дэмжихгүй байна. Харин Бээжингийнхэн Чили дэх Пиночетийн милитарист фашист дарангуйллыг дэмжиж байна.

Тэд мөн Өмнөд Африкийн Ботагийн дэглэмээс Намиби болон Анголын эсрэг үйлдэж байгаа дайснасан үйл явууллагыг дэмжиж байна.

Палестиныг чөлөөлөх байгууллагыг устгах, арабын газар нутгийг эзэлсэн хэвээр байгаад зогсохгүй, тэдний нутаг дэвсгэрээс дахин эзэлж, империализмыг эсэргүүцэгч фронтыг задлан бусниулах зорилготой израилийн Бегиний засгийн газрын сионист бодлогыг Бээжингийнхэн бас л дэмжиж байна.

Тэд афганистаны ард түмэн, мөн Вьетнамын шударга үйл хэргийг эсэргүүцэж байна.

Америкийн империализмд тал засаж байгаа Бээжингийнхний жанжлах үйл явууллага бол Христосын сударт гардаг «Яковын мутраар Есаурын санаа бүтнэ» гэсэн зүйр үгтэй адил юм.

Бээжингийнхний булай үйл явдал нь Хятадын ард түмний эсрэг хандаж байна. Америкийн коммунист бид, энэхүү ялт хэргийг уудлан илрүүлэх явдлыг үүргээ гэж үздэг юм.

«Бид тэднийг хашраана» гэдэг бодлого бол Вашингтоны өгсөн заавар юм. Бээжинд бодлого боловсруулагч нар «Вьетнамаас савраа тат, Кампучаас савраа тат, Хил дээр өдөөн хатгахаа зогсоо» гэж АНУ-ын коммунистууд шаарддагийг мэдэх биз ээ.

ЧАН ВЕН (Кампучийн Улс Үндсээ Аврах Нэгдмэл Фронтын төлөөлөгч)

Бээжингийн их гүрний эзлэн түрэмгийлэгчид, жанжлагчдын гар хөл болсон Пол Пот-Иенг Сари-Кхиеу Самфан нарын хүйс тэмтрэгч дэглэмийг устгаж, аугаа их ялалт байгуулсны 2 жилийн ойг 1981 оны нэгдүгээр сарын 7-нд Кампучийн бүх ард түмэн ёслол төгөлдөр тэмдэглэлээ.

Бээжин, Вашингтон, Зүүн өмнөд Азийн бусад харгис хүч Пол Пот-Иенг Сари-Кхиеу Самфаны тэрхүү явууллага балран унаж байгааг ойлгохдоо саяхнаас Сианук, Сон Сан нарыг Пол Потын оронд кхмерийн харгис этгээдүүдийн удирдагчид болгон ашиглах шинэ ов мэх зохиох боллоо. Тэдний энэхүү эцсийн арга, заль балран унах нь дамжиггүй.

ПАРВАТХИ КРИШНАН (Энэтхэгийн Коммунист Намын төлөөлөгч)

...дайн ба энхийн асуудал энх тайвныг эрхэмлэгч, ардчилсан бүх хүчний өмнө тулгарч байгаа гол асуудлын нэг боллоо. Ийм нөхцөлд олон улсын тавцан дээр Хятадын шинэ удирдлагын гүйцэтгэж байгаа жигшүүрт үүрэг нь манай хоёр орон, тус хоёр намыг онцгой түгшээж байна.

Хятадын удирдагчдын энэ бузар ажиллагаа нь АНУ-ын империализм болон түүний НАТО-гийн холбоотнуудтай ичгүүр сонжуургүй илэрхийгээр сүлбээлдэж, дэлхийн фашист, арьсны үзэлт болон харгис дэглэмүүдийг дэмжиж, вьетнамын баатарлаг ард түмний эсрэг дайн түрэмгийлэл үйлдэж, Пол Потын нуран унасан бүлгийг дэмжин тэтгэж, ЗХУ-ын эсрэг империализм, харгис хүчний бүх дэлхийн фронт бий болгохыг илэн далангүй уриалж байгаагаас илэрхий байна.

Учир иймд маогийн дараахи үед хятадын дотоод бодлогод гарсан зарим нэгэн өөрчлөлт нь Хятад жанжлан түрэмгийлэх бодлогоосоо ухарсан мэтээр төөрөгдөлд хүргэх ямар ч бодит үндэсгүй юм.

Бидний оршин суугаа бүс нутаг Вашингтон-Бээжингийн хуйвалдаан идэвхижсэн төв болоод байна.

ДИНИС ФЕРНАНДЕС МИРАНДА (Португалийн Коммунист Намын төлөөлөгч)

Португалийн Коммунист Намын эрс хатуу зэмлэн буруушааж байгаа хятадын удирдагчдаас БИМАУ-ын эсрэг явуулж байгаа байнгын өдөөн хатгалга нь империализмын дайнч түрэмгий стратегитай холбоотой юм.

ПУЛА КУКУЛА (Грекийн Коммунист Намын төлөөлөгч)

Империализмтай сүлбээлдэн адал балмад үзэл баримтлахын зэрэгцээгээр социализмын эсрэг үндэсний дээрэнгүй бодлого явуулж, бүс нутаг болон даян дэлхийн энх тайванд заналхийлж байгаа хятадын эрх баригчдыг Грекийн Коммунист Нам буруушааж байна.

РАКОТОБЕ РЕМИ (Мадагаскарын Тусгаар Тогтнолын Конгресс Намын төлөөлөгч)

Империализмын колонийн систем үндсэндээ устлаа. Гэвч Африк дахь жижиг улс орнууд колонийн дарлалыг амссаар байгаа болохоор бид ч бүрэн тусгаар тогтнолоо олж чадсан гэж үзэж болохгүй юм. Иймээс манай улс Сахарын ард түмэн, Баруун Өмнөд Африкийн Ардын чөлөөлөх байгууллага-СВАПО-гоор толгойлуулсан Намибын ард түмэн, Африкийн Үндэсний Конгрессоор толгойлуулсан Өмнөд Африкийн ард түмэн, Палестины чөлөөлөх байгууллагаар толгойлуулсан палестиний ард түмний тэмцэл, Сальвадор, Пуэрто-Рикийн ард түмнээс америкийн империализмын дарлалаас чөлөөлөгдөхийн төлөө явуулж буй тэмцлийг зүйл бүрээр дэмжиж байна. Ангол, Афганистан, Вьетнам, Лаос, Кампучийн эсрэг америкийн империализм, өмнөд африкийн арьсны үзэлтнүүд, хятадын жанжлах үзэлтнүүдээс явуулж буй зарласан, зарлаагүй дайныг бид эрс зэмлэн буруушааж байна.

БАРБАРА КУРТОЙЗ (Австралийн Социалист Намын төлөөлөгч)

Бид 1979 онд Вьетнамын эсрэг хийсэн хятадын түрэмгийллийг хот, хөдөөд өргөн жагсаал хийх замаар идэвхтэй эсэргүүцсэн юм. Империалист гүрнүүдтэй түнширхэн сүлбээлдэхээ зогсоож, ЗХУ болон социалист бусад оронтой харилцаагаа хэвийн болгохыг хятадын засгийн газарт уриалж байгаа хүчинтэй бид санал нэг байна.

АЖОЙ КУМАР РОЙ (Бангладешийн Коммунист Намын төлөөлөгч)

Монголын хувьсгал ялснаас хойш өнөөдрийг хүртэл 60 жилийн дотор дэлхий дээр ихээхэн өөрчлөлт гарлаа. Дэлхийн социалист систем бүх талаар шинэ амжилт олов. Шинэ тутам тусгаар тогтнолоо байлдан олсон улсуудын дотроос олон орон капиталист биш хөгжлийн замыг сонгон авлаа. Дэлхийн олон өнцөг буланд хувьсгалт үйл явц шинэ шинэ амжилтанд хүрсээр байна. Империализм, монополийг эсэргүүцсэн ард түмний тэмцэл өргөжиж шинэ амжилт олж байна.

Ийм нөхцөлд мөн капитализмын ерөнхий хямрал гүнзгийрч байгаа энэ үед империалистууд болон тэдний шинэ хань хамсаатан хятадын эрх баригч маоист бүлгийнхэн бүтэшгүй зүйлийг хийж түүхийн урагшлах явцыг зогсоохыг оролдож байна.

...Бусдын нутагт өнгөлзсөн маоист хятадын санаархлыг няцааж байгаагаараа Монгол улс дэлхийн энэ районд энх тайвныг хамгаалах хэрэгт зохих хувь нэмэр оруулж байгааг бид бас өндөр үнэлж байна.

ЕӨРГ КУЛЕ (Баруун Берлиний Нэгдмэл Социалист Намын төлөөлөгч)

Бээжингийн эзэрхийлэн жанжлах санаархлын эсрэг шийдвэртэй тэмцэн түүнчилэн империализмын харгис хүчинтэй сүлбээлдэн дайны бэлтгэлийг хүчтэй болгон үүгээрээ энхийн үйлсэд ноцтой аюул бий болгож байгаа Бээжингийн удирдагчдыг хазаарлан зогсоохын төлөө үйлсээрээ БНМАУ энх тайвны төлөө тэмцэлд хувь нэмрээ оруулж байна.

ХАРРИ ПЕРСОД НОКТА (Гайаны Ардын Дэвшилт Намын төлөөлөгч)

...Азийн бусад орнуудтай сайн хөршийн харилцааг тогтоон хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөтгөх хэрэгт Та нөхөд ямагт тэргүүн эгнээнд явж дэлхийн энэ хэсэгт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд мэдэгдэхүйц хувь нэмрээ оруулж байна.

Ялангуяа Хятад улстай сайн хөршийн хэвийн харилцааг хөгжүүлэхийн төлөө та бүхний гаргаж байгаа хүчин чармайлтад баяр хүргэж байна.

...Гүнзгий хямралд ороод байгаа капитализм, империализмыг Бээжингийн эрх баригч бүлгийнхэн өөгшүүлж байгаа боловч тэд ялж чадахгүй. Энэ бол бас л түүхийн жам ёс билээ.

ТОМАС СИНУРАЙЯ (Индонезийн Коммунист Намын төлөөлөгч)

Одоогийн Хятадын эрх баригчдын явуулж байгаа социализм, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, намжмал байдлын эсрэг чиглэсэн жанжлах, эзлэн түрэмгийлэх бодлогыг монголын ард түмэн МАХН-ынхаа удирдлагаар амжилттай эсэргүүцэж байгаа нь бахдууштай хэрэг. Маоистууд ялт төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө өөрийн нөлөөнд автагсдыг ЗХУКН, Зөвлөлт Холбоот Улсаас хөндийрүүлэн салгахыг чармайж байна. 1960-аад оны үед Индонезийн Коммунист Намын зарим удирдагч энэ хорон санаат бодлогод хэлмэгдсэн юм.

Танай орон, танай ард түмэн газар зүйн байрлалынхаа эрхээр хятадын эрх баригчдын хорон санаат ажил явууллагад шууд өртөж байгааг дэлхий даяар сайн мэдэх бөгөөд бээжингийнхэн юуны өмнө ЗХУ-тай Монгол улсын тогтоосон мөнхийн найрамдлыг эвдэн бусниулах замаар Монгол улсыг эрхэндээ оруулахыг оролдож байгаа юм.

Бээжингийн энэ ялт бодлогыг няцаахад чиглэсэн танай амжилттай үйл ажиллагаа нийтийн бахархал хүндэтгэлийг зүй ёсоор хүлээж байна.

КЛОД ДЕМЕРС (Канадын Коммунист Намын төлөөлөгч)

Вашингтон дахь Цагаан байшингийн шинэ эрх баригчид даян дэлхийн улс түмний аюулгүй байдал, ирээдүйд заналхийлэн манай гаригт хүйтэн дайн, тогтворгүй байдлын голомтыг бий болгох бодлогоо хэрэг-

жүүлэхээр хятадтай милитарист эвсэл холбоо байгуулах гэснийгээ хүлээн зөвшөөрч байгаа энэ үед Европт пуужинт цөмийн шинэ хэрэгсэл байрлуулахыг азнах тухай ЗХУ-ын Коммунист Намын XXVI их хурлаас дэвшүүлсэн бодит саналыг хариуцаж хүлээж авахад нь улс орны төрийн тэргүүн нарт бүхий л талаар нөлөөлөх нь чухал байна. Харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенцид гарын усэг зуруулахад аятай нөлөөлөл үзүүлэх үүднээс Азийн орнуудын бага хурал хийлгэх гэсэн БНМАУ-ын санал нь Ази тивд энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ихээхэн тус дөхөм үзүүлэх болно.

ИОАННИДЕС ХРИСТОФОРΟΣ (Киприйн Хөдөлмөрчин Ардын Дэвшилт Намын төлөөлөгч).

...Кампучийн ард түмэнд учирсан эмэгнэлт явдал бол тохиолдлын чанартай зүйл биш гэдгийг киприйн ард түмэн сайн мэддэг. Энэ бол нэг хэсэг солиотой хүмүүсийн явуулсан үйл ажиллагаа ч биш үүний цаана эл районд америкийн империализмтай нэгэн адил ашиг сонирхол бүхий бодлого явуулж байгаа маоист жанжлах үзэлтний хар санаат харгис хүчин байсан юм.

Эдгээр харгис хүчний эсрэг Улс Үндсээ Аврах Нэгдмэл фронтын удирдлагаар явуулж ялалт байгуулсан кампучийн ард түмний тэмцэл нь империализм, жанжлах үзэлтний эсрэг хийж байгаа бүх дэвшилт хүчний тэмцлийн бүрэлдэхүүн хэсэг нь байсан билээ. Түүнчилэн Ази тив ялангуяа Зүүн өмнөд Ази, Ойрхи Дорнодын нилээд районд хурцадмал байдал хэвээр байгаа нь хятадын удирдагчдаас явуулж байгаа их гүрний эзлэн түрэмгийлэх санаархал, империалистууд тэдний гар хөл бологсодын дайсагнасан үйл ажиллагааны шууд үр уршиг юм.

Хятадын их гүрний дээрэнгүй үзэлтэн нар америкийн империализмтай ойртон хамсаж байгаа нь Ази болон даян дэлхийн энх тайвны үйлсэд ноцтой аюул занал учруулж байна.

Хятад-Америкийн энэхүү сүлбэлдээн нь маоист удирдагчдаас хөрш зэргэлдээ оршдог социалист Вьетнам улсын эсрэг шинэ зэвсэгт түрэмгийлэл үйлдэхэд хүргэсэн гэдэгт одоо хэн ч эргэлзэхгүй. БНСВУ-ын эсрэг Хятад улс шинээр ялт халдлага хийсэн нь Азийн орнуудын талаар хятадын явуулж байгаа бодлогын жанжлан түрэмгийлэх мөн чанарыг даян дэлхийд илчлэн харууллаа.

БНСВУ-ыг түрэмгийлж довтолсон нь хятадын одоогийн удирдлага маогийн их гүрний дээрэнгүй бодлогыг хэвээр үргэлжлүүлж байгааг дахин нотолсон юм.

МОСЕС МАБИДА (Өмнөд Африкийн Коммунист Намын төлөөлөгч)

Энх тайванд аюул занал үнэхээр учирч байна гэж бид үзэж байна. Халуун цөмийн сүйрлээс сэргийлэн хамгаалах нь хүн төрөлхтөнд тулгарч байгаа нэн чухал асуудал болж байна. Ийм учраас юманд бодитойгоор ханддаг эрүүл саруул ухаантай бүх хүн ЗХУКН-ын XXVI их хурал дээр нөхөр Брежневээс дэвшүүлэн тавьсан 80-аад оны энх тайвны программыг дэмжихгүй байж яахин болох билээ.

ПЕДРО АЛВАРЕС (Парагвайн Коммунист Намын төлөөлөгч)

Марксизм-ленинизм, хувьсгалт хүчин улс түмнүүдийн үндэсний болон нийгмийн чөлөөлөлтийн үйл хэрэгт урван тэрсэлсэн бээжингийн эрх баригчид АНУ-аас дээрх санаархлаа хэрэгжүүлэхэд нь эвсэн сүлбээлдэж, шууд туслалцаа үзүүлж байна.

АЛЬ ФАРХА РАМИ (Оирийн Коммунист Намын төлөөлөгч)

Дэлхийн коммунист, ажилчин хөдөлгөөний эгнээнээс урван салж коммунист хөдөлгөөнийг хагалан бутаргах замд орж, марксизм-ленинизм, ЗХУ болон социалист орнуудыг эсэргүүцэн тэмцэж, империализм түү-

ний гар хөл бологсодтой эвсэн нэгдэж байгаа Бээжингийн харгис хүчинтэй тэмцэх, дэлхийн коммунист хөдөлгөөний эв нэгдлийг бэхжүүлэх хэрэгт оруулж байгаа танай хувь нэмрийг бид бахархан ширтэж байна.

Марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмыг ариун тунгалаг байлгах, баруун зүүн оппортунизмын бүх хэлбэрийн эсрэг тэмцэх хэрэгт танай оруулж байгаа хувь нэмрийг бид мөн өндөр үнэлж байна.

БРЮС СКИЛТОН (Шинэ Зеландын Социалист Нэгдлийн Намын төлөөлөгч)

Хятадын Коммунист Намын удирдлага марксизм-ленинизмын чиг шугамаас ухарч, одоо АНУ-ын баруун жигүүрийн империалист хүчинтэй сүлбээлдэхэд гол анхаарлаа чиглүүлж, жанжлах бодлого явуулж байна. Хятадын энэ аюултай чиг шугам чухам юунд хүргэх нь хэн бүхэнд тодорхой байна.

Пролетарийн интернационализмаас ухарвал ангийн дайсны өмнө нэгдэл нягтралаа сулруулна гэсэн үг юм.

ВЕДИККАРА АЛЬСОН (Шри Ланкийн Коммунист Намын төлөөлөгч)

Империалистууд бээжингийн жанжлагчидтай сүлбээлдэж, олон улсын энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны эрх ашгийг үл харгалзан, дэлхий дахинд хүнд байдлыг шатлан өргөжүүлэх аюултай бөгөөд ялт үйл ажиллагаа ичгүүр сонжуургүй явуулж байгаа энэ үед танай намын XVIII их хурал болж байна. Тэд Ази тив, ялангуяа, Энэтхэгийн далай, Персийн булангийн хавь нутгийг сөргөлдөөн, мөргөлдөөний бүс болгон хувиргах аюултай замд ороод байна.